



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 4/232

Мандалговь

“Инженерийн хийцтэй худаг шинээр гаргах ажил”-ыг
хүлээн авах комисс томилох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 33 дугаар зүйлийн 33.5, Сангийн сайдын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, тайлагнах журам”-ын 4.3.4 дугаар заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. 2021 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцаар хэрэгжиж буй “Шинэ хөдөө” төслийн хүрээнд нийлүүлэгдэх багц-3 буюу “Инженерийн хийцтэй худаг шинээр гаргах ажил”-ыг /Сайнцагаан, Баянжаргалан сум/ хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Ж.Батбилэг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга)
Нарийн бичгийн дарга:	Д.Энхтуяа (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)
Гишүүд:	Т.Цэвэлмаа (Баянжаргалан сумын Засаг дарга) Ц.Лхагвасүрэн (Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга) Н.Дашдорж (“Эхний эхэн” ХХК-ний нягтлан бодогч)

2. “Инженерийн хийцтэй худаг шинээр гаргах ажил”-ыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Ж.Батбилэг)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ДОРЖБАТ



426211185